

**Ц.МӨНХБАТ**

Улсын Ерөнхий Прокурорын туслах ял
эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт
хариуцсан хэлтсийн дарга

Хураангуй илтгэл

ХОРИХ ЯЛ ЭДЛЭХ ЯВЦАД ҮЙЛДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Хорих байгууллагад ялтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх нь байнгын шинжтэй болсон. Тухайлбал 2012 онд 19, 2013 онд 20, 2014 оны 3 дугаар улиралд 16 нийт 55 гэмт хэрэг, зөрчлийн тухайд 2012 онд 130, 2013 онд 208, 2014 оны 3 дугаар улирлын байдлаар 16 нийт 468 зөрчил тус тус гарсан байна.

Хорих ял эдэлж байгаа ялтны 72 буюу 1.6 хувь нь хөнгөн, 1373 буюу 21 хувь нь хүндэвтэр, 2510 буюу 36,7 хувь хүнд, 2779 буюу 41,2 хувь онц хүнд гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байна.

Үүнээс: Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа ялтны тоо 5289 буюу 77,9 хувь байгаа нь зөрчил гарах нэг нөхцлийг бүрдүүлж байна.

САХИЛГЫН ШИЙТГЭЛ ХҮЛЭЭСЭН БАЙДАЛ

2013 оны 3 дугаар улирал		2014 оны 3 дугаар улирал
1.Ээлжийн бус ажил хийлгэх	180	159
2.Хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх	61	26
3.Сахилгын байранд хорих	139	110
4.Шагналын хоног хасах	74	83
Бүгд	454	378

Хорих ял эдлэх явцад үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл нь

1. Төр буюу түүнийг төлөөлж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих анги, албан хаагчийн идэвхгүй үйлдэл
2. Ялтны хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байдал

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ДОТООДОД БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХҮРЭЭНД:

- Гэмт хэрэг зөрчил гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах
- Албан хаагчдыг ГХУС чиглэлээр мэдээллээр хангах, хууль тогтоомжийг сурталчлах
- Хорих ангийн аюулгүй байдал, түүнд мөрдөгдөх дэг журмыг сахиулах чиглэлээр ялтанд байгаа хяналт тавих
- Гарсан гэмт хэрэг зөрчлийг илрүүлэхийн тулд ялтнуудын дунд хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах
- Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах
- Хорих байгууллагын нэгж салбар бүрийн онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах

Санал

- Хорих байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх
- Хорих ял эдэлж байгаа ялтны үйлдсэн гэмт хэрэг зөрчлийн илрүүлэлтийг сайжруулах ажлын сөрөг үзүүлэлтэд тооцохгүй байх
- Ялтны үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шуурхай шийдвэрлүүлж байх
- Хорих ангийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, дотоод хяналтыг шинэ шатанд гаргах
- Ялтны хууль журамд заасан эрх үүргийг эдлүүлэх, үйлдсэн зөрчилд нь тохирсон шийтгэлийг тухай бүр үндэслэлтэй оногдуулж байх



